

Сэдэв: Уран нийтлэлийн сэдэв, гол санааг түлхүүр үгээр тодорхойлох

Дараах уран нийтлэлийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

БУЯНТ УХАА

Буянт –Ухаа гэдэг нэрийг анх сонсоход, аавын минь мөр тохойд нь гарын тос арчсан хул торгон тэрлэг давын өмнө санаад орж билээ. Ардын дуу шиг энэ нэрийг дахин дахин сонсох бүрий үүрийн сэрүүнд нялх унага тэнцэн босох намжаа толгод, олон адууны хөлөөр алтран босох шаргал тоос сэтгэлд буудаг байлаа.

Олон жилийн баяр наадмын тос буянт шингэсэн энэ талбар саяхан хурдан морьдын барианы газар байсан бол эдүгээ монгол хүнд цэнгэлийн жигүүр ургуулах гарааны газар болжээ.

Буянт-Ухаа ирэх шувуудаа хүлээх хаврын нуур шиг тэнгэр ширтэж байна. Тэнгэр ширтэх билгүүн мэлмий нь алтан гадас од лугаа замбуулин хурмастын тохиох орд байнам.

Тэнгэр аялахад дэлхийн нэр Буянт-Ухаа

Газар явахад гэрийн минь нэр Буянт –Ухаа

Ж.Лхагва

1. Дараах үгийн утгыг тайлбарлаарай.

- | | |
|--------------|---|
| 1. Ухаа | a) Цэцэн ухаантай |
| 2. Намжаа | b) Манай дэлхийн өөр нэр. |
| 3. Билгүүн | c) Тал газар буй өндөрхөн зоо, гүвээ газар, |
| 4. Замбуулин | d) Гучин гурван тэнгэрийн нэг |
| 5. Хурмаст | e) Дөлгөөн тайван, амар амгалан |

- A. 1e2c3a4d5b
- B. 1e2b3a4e5d
- C. 1c2e3a4b5d
- D. 1c2e3a 4d5b
- E. 1e2b3a4d5c

2. Дээрх бичил нийтлэл хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

3. Эхийн агуулгын хэсэг тус бүрийн санааг илэрхийлсэн түлхүүр үгийг олоорой. Зөвийг сонгон харгалзуулна уу.

- | | |
|------------------|--------------------------------------|
| 1. Эхлэл хэсэг | a) Барианы газар, гарааны газар, орд |
| 2. Гол хэсэг | b) Аав, ардын дуу |
| 3. Төгсгөл хэсэг | c) Тэрлэг, толгод, тоос |
| | d) Буянт-Ухаа, нэр |
| | e) Хурдан морь, наадам |
| | f) Дэлхий, гэр |

- A. 1b2e3c
- B. 1c2a3f
- C. 1c2a3d
- D. 1d2a3f

4. Түлхүүр үгсийн ил ба далд утгыг сайтар нягтлаад, нийтлэлийн сэдвийг тодорхойлоорой.

- A. Буянт-Ухаа нэрийн тухай
- B. Онгоцны буудлын тухай
- C. Наадмын тухай
- D. Байгалийн тухай

5. Сэдвээр дамжуулан нийтлэлд ямар асуудал дэвшүүлснийг тодорхойлоорой.

- A. Буянт-Ухаа нэрээр дэлхийд Монгол танигдаж буй тухай
- B. Онгоцны буудалтай болж, улс орон хөгжиж буй тухай
- C. Наадам бол монголчуудын уламжлалт баяр наадам болох тухай
- D. Буянт-Ухаа бол байгалийн нэгэн уран зураг болох тухай

6. Дээрх нийтлэлийн гол санааг тодорхойлоорой.

- A. Буянт-Ухаа нэрээр Монгол улс дэлхийд танигдаж, хөгжин мандаж байна.
- B. Онгоцны буудалтай болж, улс орон хөгжин, харилцаа өргөжиж байна.
- C. Наадам бол монголчуудын цэнгэлийн манлай болсон уламжлалт баяр.
- D. Байгалийн нэгэн уран зураг болох энэ газар эзнээ хүлээж байна.

7. Уг нийтлэлийн гол сэдэв, гол санааг батлах, дэмжсэн үг, хэллэгүүдийг олоорой.

- A. Хул, тэрлэг, толгод, тоос
- B. Наадам, хурдан морьд, барианы газар
- C. Цэнгэлийн жигүүр ургуулах гарааны газар, ирэх шувуудаа хүлээх, замбуулин хурмастын тохиох орд, дэлхий
- D. Нэр, талбар, гарааны газар, орд, дэлхий, гэр

Дараах эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

ЗУЛ

Өргөн тасгалгааны үүдийг нээмэгц хоёр хуруу лааны гэрэл сүүмийн үзэгдэж, холоос ирсэн зочны урмыг эвдэх нь тун ч уйтгартай байтал удалгүй цаад тасгалгааны дотроос залуу бүсгүй гарч ирэн, чийдэнгийн товчийг мушгиагц түүний зүрхний дотор басхүү зул ноцож, сэтгэл хөгжөөд, даруй бийрийг авч, шүлэг зохион эхлэв.

Д.Нацагдорж

8. “Зул” бичил уран нийтлэл нь хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4

9. Эхийн агуулгын хэсэг тус бүрийн санааг илэрхийлсэн түлхүүр үгийг олоорой. Зөвийг сонгон харгалзуулна уу.

- | | |
|------------------|-------------|
| 1. Эхлэл хэсэг | a) тасалгаа |
| 2. Гол хэсэг | b) бүсгүй |
| 3. Төгсгөл хэсэг | c) чийдэн |
| | d) лаа |
| | e) зул |
- A. 1a2b3e
B. 1d2c3e
C. 1d2b3e
D. 1b2c3a

10. Түлхүүр үгсийн ил ба далд утгыг сайтар нягтлаад, нийтлэлийн сэдвийг тодорхойлоорой.

- A. Улс орны тухай
B. Хайрын тухай
C. Хөгжлийн тухай
D. Бүтээл туурвилын тухай

11. Сэдвээр дамжуулан нийтлэлд ямар асуудал дэвшүүлснийг тодорхойлоорой.

- A. Өргөн уудам газар нутагтай орны тухай
B. Хайр бол сэтгэлийн илч, гэрэл болох тухай
C. Улс орон хөгжиж эхэлж буй тухай
D. Бүтээл төрөх үүдэл санааны тухай

12. Дээрх нийтлэлийн гол санааг тодорхойлоорой.

- A. Монгол бол өргөн уудам газар нутагтай орны нэг.
B. Хайр бол сэтгэлд гэнэт үүсдэг оч, гэрэл.
C. Улс орон бүхэлдээ биш гэхэд хэсэг газарт хөгжлийн эхлэл тавигдаж байна.
D. Бүтээл төрөх үүдэл санаа бол аливаа тохиолдсон үйл явдал.

13. Уг нийтлэлийн гол сэдэв, гол санааг баталж, дэмжсэн үг, хэллэгүүдийг олоорой.

- A. Зочин, бүсгүй, шүлэг
B. Тасалгаа, лаа, чийдэн
C. Урам, уйтгар, зүрх, зул
D. Зул, бийр, шүлэг

14. Дээрх хоёр нийтлэлийн сэдэв, гол санааг харьцуулан ижил ба ялгаатай талыг тайлбарлаарай. Зөв хариултуудыг тэмдэглээрэй.

- A. Дээрх хоёр нийтлэл нь сэдвээрээ ижил
B. Дээрх хоёр нийтлэл нь сэдвээрээ ялгаатай.
C. Дээрх хоёр нийтлэл нь гаргасан гол санаагаараа ижил.
D. Дээрх хоёр нийтлэл нь гаргасан гол санаагаараа ялгаатай.
E. Дээрх хоёр нийтлэл нь харуулсан нийгэм, цаг хугацаагаараа ялгаатай
F. Дээрх хоёр нийтлэл нь харуулсан нийгэм, цаг хугацаагаараа ижил
G. Дээрх хоёр нийтлэл нь өгүүлэгдэж буй юмаараа ялгаатай.
H. Дээрх хоёр нийтлэл нь өгүүлэгдэж буй юмаараа ижил

